



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 2/17

Улсын төсвийн орлого
төвлөрүүлэх тухай

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Мөнхийн тун ХХК-тай түрээсийн төлбөрийг 90 метр квадрат талбайгаар тооцон гэрээ байгуулсан байтал хэмжилтээр 116.2 метр квадрат талбайтай байна. Зөрүү 26,2 метр квадрат талбайн түрээсийн төлбөр 2,200,800 төгрөг, мөн эмнэлгийн байрны 1 давхарт байрлах Цайны газрын 120 метр талбайн түрээсийг гэрээ байгуулалгүйгээр, үнэ төлбөргүй ашиглуулсны төлбөр 10,080,000 төгрөгийн, нийт 12,280,800 төгрөгийн орлого дутуу бүртгэсэн байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дугаар заалт "...үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ", 28 дугаар зүйлийн 28.5 дугаар заалт "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна..." гэснийг, Засгийн газрын 2004 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 16 дугаар заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." гэснийг, Ерөнхий аудиторын 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 47-р тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. 2013 онд төрийн өмчийн хөрөнгө түрээслэсний орлого болох түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн хорооны 2007 оны 2 сарын 8-ны өдрийн 42 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод үнэ"-ийг баримтлан тооцоолж 12,280,800 төгрөгийг Төрийн сан дахь улсын төсвийн 900000601 тоот дансанд 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэх
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гэмтэл согог сэргээн засалтын үндэсний төвийн захирал Ц. Энхбаяр, ерөнхий нягтлан бодогч С. Бямбанайдан нарт хариуцуулав.

ТОГТООСОН: Аудитор


Б. Сэржмяда

УХА0122

АКТЫГ



ЗӨВШӨӨРСӨН:

ГССҮТөвийн захирал
Ц. Энхбаяр
Ерөнхий нягтлан бодогч
С. Бямбанайдан



071151